



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 15 өдөр

Дугаар А992

Улаанбаатар хот

Г Эзэмшиж буй газрыг бусдад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 дэх хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эзэмшиж буй газраа шилжүүлэхээр хүсэлт гаргасан 4 (дөрөв) иргэний газрыг хавсралтад зааснаар шилжүүлсүгэй.

2. Эзэмшиж буй газрыг шилжүүлэн авсан иргэнтэй холбогдох хууль тогтоомж, эрхийн актын дагуу гэрээ байгуулж, гэрчилгээ олгон, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Газар зохион байгуулалтын алба (Ч.Магадсайхан)-нд үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2007 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 145, 2015 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн А/42 дугаар захирамжийн Б.Хүрэл-Эрдэнэ, 2021 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн А/160 дугаар захирамжийн Б.Даваасүрэн, 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/48 дугаар захирамжийн Б.Даваасүрэн нарт хамаарах заалтыг тус өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД